



**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСӨЛД ӨГӨХ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ**

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛД ӨГӨХ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

2024 оны 5 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Засгийн газраас Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөлтэй уялдуулан “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1 дэх заалтын дагуу Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах” тухай УИХ-ын тогтоолын төсөлтэй танилцаж, “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн 16¹.1 дэх заалтад заасны дагуу дор дурдсан дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Нэг. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн хоорондын уялдаа, хамаарал

“Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль нь Үндсэн хуулийн “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлах”, “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх” зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд 25 дугаар зүйлийн 25.1.7-д заасан “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” харилцааг зохицуулдаг. Түүнчлэн тус хуульд урт хугацааны хөгжлийн бодлого нь зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээс, харин дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь зорилго, зорилт, үйл ажиллагаа, хүрэх үр дүн, санхүүгийн эх үүсвэр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээс бүрдэхээр тогтоосон.

Энэ хүрээнд Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуульд нийцүүлэн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрийн “бодлогын үндэслэл”-ийг Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн холбогдох заалтуудтай уялдуулан боловсруулсан байна. Гэсэн хэдий ч дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Аливаа улс орны хөгжлийн бодлого төлөвлөлт нь төсөв, санхүүгийн нөөцийг хуваарилах асуудалтай нягт уялдаатай төдийгүй урт хугацааны хөгжлийн стратеги төлөвлөлт нь дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт болон жилийн хөгжлийн төлөвлөгөөг дотроо агуулдаг. Манай улсын хувьд урт хугацааны хөгжлийн төлөвлөлт нь Алсын хараа-2050”, харин дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт нь 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөр, богино хугацааны хөгжлийн төлөвлөгөө нь тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнөөс бүрдэж байгаа юм. Гэвч Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд тухайлбал, “Алсын хараа 2050”, “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөө болон 2025-2027 оны Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл,

түүний дотор төсвийн зарлагын хоорондын уялдаа, хамаарлыг тогтооход учир дутагдалтай байна.

2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төслүүдийн хэрэгжих боломж нь санхүүжилтийн эх үүсвэрээс шууд хамааралтай. 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд 11.9 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 224 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 3.7 их наяд, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 1.4 их наяд, төр хувийн хэвшлийн хөрөнгөөр 2.6 их наяд, гадаад, дотоод хөрөнгө оруулалтаар 1.4 их наяд, бусад эх үүсвэрээс 1.6 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцжээ.

Төслүүдийн санхүүжилтийг тодорхой зааж өгөхийн гол зорилго нь Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөөлөл дэх төсвийн зарлагыг хязгаарлах явдал юм. Ийм учраас авто болон төмөр зам, эрчим хүч, аж үйлдвэрийн парк зэрэг зардал ихтэй стратегийн төслүүдийн эдийн засгийн үр ашиг, өгөөжийг сайтар тооцож, санхүүжилтийн эх үүсвэрийг илүү тодорхой болгох хэрэгтэй.

3. Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөлд төсвийн зарлагыг 31.3 их наяд төгрөг (2024 оны батлагдсан дүнгээс 14.3 хувиар нэмэгдсэн) буюу ДНБ-ий 32.9 хувь, төсвийн алдагдлыг -1.9 их наяд төгрөг буюу ДНБ-ий -2.0 хувь байхаар УИХ-д өргөн мэдүүлсэн. Түүнчлэн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлээр улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 29.4 их наяд төгрөгт буюу ДНБ-ий 30.9 хувьд хүрэхээр байгаа нь 2024 оны батлагдсан дүнгээс 3.5 их наяд төгрөгөөр нэмэгдэж, 13.5 хувиар өсөхөөр хэт өөдрөг тооцсон байна. Харин Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан төсөөллөөр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 26.2 их наяд төгрөгт хүрэхээр байгаа нь төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан орлогоос 3.2 их наяд төгрөгөөр бага байна.

Бодит байдалд экспортын болон төсвийн гүйцэтгэл төсөөлж буй хэмжээнээс буурах, төсвийн орлого тасалдах, улмаар улсын төсвийн алдагдал нэмэгдэх, 2025 оны улсын хөгжлийн болон төсвийн төлөвлөгөөнд тусгагдсан ч орлого, санхүүжилтийн тасалдлын улмаас хэрэгжиж буй үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт зогсох, он дамжих хөрөнгө оруулалт, барилга объектын тоо нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсэх магадлал өндөр байна. Иймд Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг бүхэлд нь хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал гэж үзэж болохоор байна.

Хоёр. Бодлогын тэргүүлэх чиглэл, жилийн төлөвлөгөөний зорилго, зорилт, үр дүн ба хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт хоорондын уялдаа, нийцэл

“Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн 4.1.13-т заасны дагуу “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” нь “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичиг” юм. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хавсаргасан “Монгол улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-д “Эдийн засгийн өсөлтийн өгөөжийг өрх бүрд хүргэх”-ээр бодлогын найман тэргүүлэх чиглэлийн хүрээнд 31 зорилгод хамаарах 224 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна (Хавсралт 2).

Жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа 31 зорилго, 224 зорилтыг хэрэгжүүлснээр Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд 30 үр дүн, хөтөлбөрийн 58 үр дүнд хүрэхээр тооцжээ. Эдгээр үр дүнг хангахын тулд 216 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн тэдгээрийг хэмжих 253 шалгуур үзүүлэлт тодорхойлж, шалгуур үзүүлэлт бүрээр 2023 оны суурь (216 үзүүлэлт) болон 2025 оны зорилтот (253 үзүүлэлт) үр дүнгийн гэх үзүүлэлтийг тодорхойлжээ. Гэхдээ нийт шалгуур үзүүлэлтийн 14.6 хувь буюу 37 шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг огт тусгаагүй байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний төсөлд тусгагдсан бодлогын тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх зорилт, төсөл, арга хэмжээ ба шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот үр дүнгийн үзүүлэлтийг харьцуулан судалж үзээд дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

1. Жилийн төлөвлөгөөг “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-тэй уялдуулан бодлогын 8 тэргүүлэх чиглэлийг баримтлахаар (УИХ-ын тогтоолын төслийн 1-р хавсралт) тогтсон нь сайшаалтай ч “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө” (УИХ-ын тогтоолын төслийн 2-р хавсралт)-нд эдгээр тэргүүлэх чиглэлийн зарим зорилтыг огт тусгаагүй, эсвэл түүнд нийцэхгүйгээр тодорхойлсон үр дүн, төсөл, арга хэмжээ цөөнгүй байна. Тухайлбал, тэргүүлэх чиглэлийн 2.1 дэх “Үндэсний орон сууцжуулах хөтөлбөрийг баялгийн сантай уялдуулж хэрэгжүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд дэвшүүлсэн гурван зорилтын агуулга 2025 оны төлөвлөгөөнд огт тусгаадаагүй.

Түүнчлэн 3 дахь тэргүүлэх чиглэл болох “Шинжлэх ухаан, дэвшилтэт технологид тулгуурласан засаглалын бодлого”-ын хүрээнд баримтлахаар тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг жилийн төлөвлөгөөнд өөрчилж оруулсан байна.

Тухайлбал, зөвхөн “шинжлэх ухааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” гэж тэргүүлэх чиглэлийн 3.1-д нийцэхгүй өөр зорилт бичсэн, мөн 3.2-т “Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ” гэж тэргүүлэх чиглэлийн зорилтыг өөрчилсөн, 3.3 буюу “Хүний эрхийн баталгааг хангах” зорилгын хүрээнд 8 зорилт дэвшүүлсэн ч зөвхөн “... түр хамгаалах байр байгуулах” ганц төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан, 3.5-д “Авлигын гэмт хэргийг бууруулна” гэж тэргүүлэх чиглэлд тусгаагүй байсан зорилтыг нэмж оруулсан, үүнээс гадна 3.6-д тусгагдсан “Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, нийгмийн баталгааг хангах”-тай холбоотой зорилго, зорилт, үр дүн, төсөл, арга хэмжээг хооронд нь уялдаагүйгээр боловсруулжээ. Энэ нь жилийн төлөвлөгөөг нэгдмэл байдлаар боловсруулаагүй, салбар, яам, агентлагаас ирсэн саналыг хамаарах чиглэлээр нь шууд нэгтгэж гаргасныг илтгэж байна.

2. Хөгжлийн төлөвлөгөөг бэлтгэхдээ бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж, бодлогын үндэслэлд нийцүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, үр дүнгийн суурь болон зорилтот түвшинг гаргахыг хичээсэн нь ахицтай алхам болжээ. Гэвч Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн SMART буюу хэмжигдэхүйц, үнэлэгдэхүйц байх шаардлагыг хангаж буй эсэх нь эргэлзээтэй, шалгуур үзүүлэлтүүд тодорхойгүй, тухайлбал, “арга хэмжээний хэрэгжилт”, “барилгын ажлын гүйцэтгэл”, “төслийн хэрэгжилт” гэх мэтээр хэт ерөнхий тодорхойлсон, зарим үзүүлэлтийн суурь түвшин байхгүй хэрнээ зорилтот түвшин нь бүгд 100 хувь гэх мэт байгаа нь бодлого, жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитойгоор үнэлэх боломжгүй болгож байна.

3. Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө нь УИХ-ын 220 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, уг тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний 2025 оны үзүүлэлтүүдийг хангаж байхын сацуу “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, 2025 онд үлдсэн зорилго, зорилт, үр дүнд хүрэхэд чиглэсэн байх ёстой. Тэгвэл “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт” (УИХ-ын тогтоолын төслийн 3-р хавсралт)-ийг боловсруулахдаа дээрх баримт бичгүүд төдийгүй “Монгол Улсын 2025 оны төлөвлөгөө”-тэй уялдуулаагүй байна.

Тухайлбал, “Тэргүүлэх чиглэлийн үр дүн” гэж тодорхойлсон 8 шалгуур үзүүлэлтийн суурь, зорилтот түвшин нь 2025 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүнг хангахын тулд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн суурь

болон зорилтот түвшний үзүүлэлттэй хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй байгаагаас гадна “Хүний хөгжлийн индекс”-ийг 2021 онд хүрсэн 96-аас 2025 онд 89 болгож бууруулахаар тооцсон нь ойлгомжгүй байна. Мөн эдгээр үзүүлэлтийг жилийн төлөвлөгөөнд огт тусгалгүй, салангид байдлаар боловсруулжээ.

Гурав. Хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилт, төсөвт үзүүлэх нөлөө

Жилийн төлөвлөгөөнд нийт 224 төсөл, арга хэмжээг тусгаж, санхүүжилтийн эх үүсвэрийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 1. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний санхүүжилтийг тодорхойлсон байдал

д/д	Санхүүжилтийн хэлбэр	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжилтийн нийт дүн Тэрбум төг	Нийт санхүүжилтэд эзлэх хувь	Санхүүжилтийн дүн тодорхойгүй төсөл арга хэмжээний тоо
1	Улсын төсөв	151	3,756.8	31.6%	33
2	Гадаадын зээл	17	1,126.1	9.5%	2
3	Төр, хувийн хэвшлийн түншлэл	13	2,588.9	21.8%	0
4	Бусад эх үүсвэр	7	1,615.6	13.6%	3
5	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	9	1,452.7	12.2%	1
6	Гадаадын зээл, тусламж	6	303.3	2.6%	0
7	Орон нутгийн төсөв	5	95.9	0.8%	3
8	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	4	171.6	1.4%	1
9	Гадаадын тусламж	4	166.7	1.4%	0
10	Улсын төсөв, гадаадын зээл	3	390.5	3.3%	0
11	Орон нутгийн төсөв, гадаадын зээл	2	151.8	1.3%	0
12	Улсын төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	1	60.0	0.5%	0
13	Улсын төсөв, гадаадын тусламж	1	3.0	0.0%	0
14	Орон нутгийн төсөв, Төр хувийн хэвшлийн түншлэл, Бусад эх үүсвэр	1	0.0	0.0%	1
	НИЙТ	224	11,883.0	100%	44

Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол

Нийт санхүүжилтийн эх үүсвэрийн 33.9 хувийг төсвийн эх үүсвэр¹, үлдсэн хэсгийг бусад 13 төрлийн санхүүжилтийн эх үүсвэр эзэлж байна. “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2-т богино хугацааны буюу нэг жилийн төлөвлөгөөний санхүүжилтийн талаар “санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх” гэж заажээ. Энэхүү заалтыг хэрэгжүүлсэн байдал болон санхүүжилтийн ерөнхий нөхцөл зэргийг харгалзан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөлд 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтыг Засгийн газрын зүгээс 7,273.0 тэрбум төгрөг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс макро эдийн засаг, төсвийн гол үзүүлэлтүүдийн таамаглалд 4,999.8 тэрбум төгрөгөөр тусгасан. Хөгжлийн төлөвлөгөөнд

¹ Төсвийн хөрөнгө оруулалтын дүнд а) Улсын төсөв, б) Орон нутгийн төсөв, в) Улсын төсөв, орон нутгийн төсөв гэсэн гурван хэсгийн дүнг хамруулсан болно.

төсвийн хөрөнгө оруулалтын нийт хэмжээг 4,024.3 тэрбум төгрөг байхаар тусгасан нь нийт санхүүжилтийн 33.9 хувийг эзэлж байна.

2. Санхүүжилтийн хувьд нийт эх үүсвэрийн 1,615.6 тэрбум төгрөг буюу 13.6 хувийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Энэ нь дээрх хүснэгтэд байгаа бусад 13 төрлийн эх үүсвэрээс өөр ямар эх үүсвэрээр санхүүжих нь тодорхойгүй байгаа юм. Гэтэл эдгээр нь стратегийн чухал ач холбогдол бүхий уул уурхайн томоохон төслүүд, тээвэр, газрын тос дамжуулах хоолойн төслүүд байна.

3. Мөн эх үүсвэр давхардсан буюу хоёр, түүнээс дээш эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ 2,532.9 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 21.3 хувийг эзэлж байна. Энэ нь тухайн төсөл, арга хэмжээ нь эдгээрийн чухам аль эх үүсвэрээр санхүүжих нь тодорхойгүй байна.

4. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төсөл, арга хэмжээний нийт дүн 2,588.9 тэрбум төгрөг буюу 21.8 хувийг эзэлж байна. Хуульд зааснаар аливаа төсөл, арга хэмжээ хариуцах эзэнтэй, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл нь батлагдсан байх шаардлагатай. Хөгжлийн төлөвлөгөөнд хариуцах төрийн байгууллагыг заасан боловч гэрээ хэнтэй хийх, хэрэгжих боломжтой зэргийг тодорхой тусгаагүй байна.

5. Хөгжлийн төлөвлөгөөний төсөлд санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй 44 төсөл, арга хэмжээ байгаагаас санхүүжилтийг зайлшгүй тодорхойлох шаардлагатай төслүүд байгаа нь өмнө дурдсан хуулийн шаардлагыг хангахгүй байна. Жишээлбэл, 1.5.2.15-д заасан улсын төсвөөс санхүүжих Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр чиглэлийн 44 км авто зам барих төсөл, гадаадын зээлийн эх үүсвэрээр санхүүжих 7.2.1.3-т “Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах” төсөл хэрэгжүүлэх (Дэлхийн банк)” хэмээн санхүүжилт авах талыг тодорхой заасан бол харин 7.2.1.6-д “Баянголын амын орлогод нийцсэн орон сууц төсөл”-ийн хүрээнд 2007 айлын орон сууцны хороолол байгуулах” хэмээн тодорхойгүй байдлаар орхисон.

6. Гадаадын зээл тусламжийн дүн 1,599.14² тэрбум төгрөг байгаа нь энэ хэмжээгээр Засгийн газрын өрийг нэмэгдүүлж болзошгүй.

7. Санхүүжилтийн бүтцийн хувьд олон төрлийн эх үүсвэрийг ашиглахыг зорьж байгаа сайн талтай мэт боловч эх үүсвэр тодорхой, оновчтой байхад анхаарах шаардлагатай. Оновчтой байдлын хувьд аль төслийг ямар санхүүжилтээр хэрэгжүүлэх асуудал ихээхэн чухал юм. Жишээлбэл, гадаадын зээл, тусламжаар орон сууц, тээвэр, дулаан, эрчим хүчний төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээс илүү ногоон хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх боломжтой.

Эндээс хэдийгээр нийт 11.9 их наяд төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч үүний хэрэгжилтийн түвшин ихээхэн эргэлзээтэй буюу төсвийн хөрөнгөөр санхүүжихээс бусад төсөл, арга хэмжээний хувьд анхаарах шаардлагатай харагдаж байна. Үүний нотолгоо нь өмнөх жилүүдийн хөгжлийн төлөвлөгөө, түүний үр дүнгийн гүйцэтгэл, санхүүжилтийн байдал болно. Тухайлбал, Үндэсний аудитын газраас 2022 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлсэн тайланд “УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хүрээнд 6 бүлэг, 23 зорилго бүхий 300 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс 262 төсөл арга хэмжээнд нийт 11,714.0 тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай гэсэн нь (ҮАГ, 2023, хууд. 6) өнөө жилийн нэгэн адил өмнөх жилүүдэд санхүүжилтийг нь тодорхойлоогүй төсөл, хөтөлбөрүүдийг баталсан байна” гэж дурджээ.

Мөн тус тайланд төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 300 төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгээр 82 төсөл, арга хэмжээ

² Гадаад зээл тусламжийн дүнд а) Гадаадын зээл, б) Гадаадын зээл, тусламж, в) Гадаадын тусламж, г) Улсын төсөв, гадаадын тусламж гэсэн санхүүжилтийн нийт дүнг хамруулсан болно.

буюу 27.3 хувь нь үр дүнтэй хэрэгжиж, 71 төсөл, арга хэмжээ буюу 23.7 хувь нь тодорхой үр дүнд хүрч, 88 төсөл, арга хэмжээ буюу 29.3 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 59 төсөл, арга хэмжээ буюу 19.7 хувь нь үр дүнгүй буюу зорилтот үр дүнг хангаагүй бөгөөд нийт 3,787.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна” (ҮАГ, 2023, хууд. 6) гэсэн нь тухайн жилд нийт батлагдсан санхүүжилтийн дөнгөж 32.3 болж байгаа бөгөөд 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээтэй ойролцоо дүн юм.

Дөрөв. 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан дэд бүтцийн зарим төслүүдийн талаар

Хөгжлийн бодлогын төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх заалтад хөгжлийн бодлогын баримт бичиг нь урт, дунд ба богино хугацааны баримт бичиг байна гээд уг хуулийн 6.7, 6.8, 6.9, 6.10 заалтуудад эдгээр баримт бичгүүдэд тавигдах шаардлагыг нарийвчлан зааж өгсөн. Тухайлбал, нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь “Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл аймаг нийслэл, хотыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх” гэж заасан.

Хуулийн энэ заалтыг үндэслэн Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө нь “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байх учиртай. Харин эдгээр баримт бичигт тусгагдаагүй аливаа шинэ төсөл, хөтөлбөрийг тусгах төдийлөн шаардлагагүй бөгөөд урт ба дунд хугацааны бодлогод тусгагдаагүй аливаа ач холбогдол багатай, олон тооны жижиг төсөл, хөтөлбөр, арга хэмжээг нэг жилийн хөгжлийн бодлогод тусгах нь бодлого ба хөрөнгийн эх үүсвэрийг тарамдуулах нэг үндсэн шалтгаан болж байна.

Ийнхүү “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгагдаагүй шинэ төсөл, хөтөлбөр, арга хэмжээг өнгөрсөн жилүүдэд төсөлд тусган батлуулж ирсэн жишээг зөвхөн төмөр зам, эрчим хүчний салбарын цөөн жишээн дээр хавсралт 1-д тайлбарлан үзүүлэв.

“Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийг батлан гаргах болсон үндсэн нэг шаардлага нь улс орны хөгжлийн бодлогыг шат дараатай зөв төлөвлөн хөгжүүлэхэд оршиж байсан тул нэг жилийн хөгжлийн төлөвлөгөөнд хэт олон төсөл, хөтөлбөр, үүний дотор шинэ төсөл, арга хэмжээг тусгахгүй байх, 5 жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэхэд хөрөнгө, хүчийг зөв чиглүүлэхэд оршиж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуульд “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна” гэж заасны дагуу цаашид 5 жилийн төлөвлөлтийн арга зүйг бүрэн нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд энэ нөхцөлд жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө нь Урт хугацааны хөгжлийн бодлого, 5 жилийн Үндсэн чиглэлд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой гэсэн зарчим, арга зүйг Засгийн газар, салбарын яамд, Эдийн засаг, хөгжлийн яам мөрдлөг болгон ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэлэлцэж, батлахдаа дараах зүйлд анхаарахыг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Дэлхийн эдийн засгийн болон геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан цаашид төсвийн орлого буурч, 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд заасан төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө хүрэлцэхгүй байх эрсдэл үүсэхээр байгааг анхаарч үзэх хэрэгтэй. Иймээс төлөвлөгөөний төсөлд тусгагдсан 224 зорилт, арга хэмжээг бодлогын тэргүүлэх чиглэлд нийцтэй байдал болон эдийн засаг, нийгэмд үзүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлж, хэрэгжүүлэх нь төсвийн үр ашигтай зарцуулалтыг нэмэгдүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөг сайжруулна.

2. Жилийн төлөвлөгөөний төслийн баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг болж байгаа УИХ-ын тогтоолын төслийн хавсралтууд буюу “Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”-ийг хооронд нь уялдаа, нийцтэй болгож, орхигдуулсан болон өөрөөр тодорхойлсон үр дүн, төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, суурь ба зорилтот түвшнийг нягтлан тусгаж, уг төлөвлөгөөний нэгдмэл, бодитой хэрэгжихүйц байдлыг нь сайжруулах шаардлагатай.

3. Тэргүүлэх чиглэлийн үр дүн, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтийг SMART буюу үнэлж, хэмжиж болохуйц байдлаар тодорхойлж, “арга хэмжээний хэрэгжилт”, “барилгын ажлын гүйцэтгэл”, “төслийн хэрэгжилт” зэрэг хэт ерөнхий, оновчгүй, тодорхойгүй шалгуур үзүүлэлтийг бодлогын зорилго, зорилт, төлөвлөгөө, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг бодитой үнэлж болохуйц болгож томъёолох, үүнтэй уялдуулан суурь түвшин нь тодорхой болоогүй үзүүлэлтийг уг төлөвлөгөөнд зайлшгүй нэмж тусгах хэрэгтэй байна.

4. Үр дүнгийн үзүүлэлтийг зөвхөн суурь болон зорилтот түвшин гэж тодорхойлох бус, харин суурь түвшин (2020 он), хүрсэн түвшин (2023 он), зорилтот түвшин (2025 он) гэж тодорхойлбол дунд хугацаанд хүрэхээр зорьсон үр дүндээ хэрхэн хүрч байгааг үнэлэх боломж олгохын зэрэгцээ урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын уялдааг тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

5. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгагдсан 224 зорилт, арга хэмжээний 16.5 хувийнх нь санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, харин 19.6 хувийнх нь хөрөнгийн хэмжээг тусгаагүй байгаа, зарим төсөл, арга хэмжээний эх үүсвэр давхцалтай байна (Хавсралт 3). Иймд санхүүжилтийн эх үүсвэрийн давхцалтай, санхүүжилт нь тодорхойгүй, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл нь батлагдсан байх шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг дахин нягталж хөгжлийн төлөвлөгөөнөөс хасах, эсвэл зорилт, арга хэмжээ тус бүрд шаардлагатай хөрөнгийн тооцоог хийж, тусгасны дараа батлах нь зүйтэй.

6. 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 11.9 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдахаас улсын төсвийн хөрөнгөөр 3.7 их наяд, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 95.9 тэрбум, гадаадын зээл тусламжаар 1,429.4 тэрбум, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар 2,588.9 тэрбум, бусад эх үүсвэрээр 1.6 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр уг тогтоолын төсөлд тусгасан байна. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт санхүүжилтийн 13.6 хувийг бусад эх үүсвэр эзэлж байгаа тул төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх “бусад” гэсэн эх үүсвэрийг илүү тодорхой болгох шаардлагатай.

7. Улсын төсвийн хөрөнгөөр 3.7 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр тооцсон хэдий ч энэ санхүүжилт төсвийн хөрөнгө оруулалтын болон урсгал зардлын хэдэн хувийг эзлэх нь тодорхойгүй байна. Энэ бүхэнд дүгнэлт хийж үзэхийн зэрэгцээ хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, бодлогын арга хэмжээ зэргээр дотор нь илүү тодорхой ангилах саналтай байна.

8. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн баталгаа нь 2025 оны жилийн төсөв болох ёстой³. Иймээс уг төлөвлөгөөнд тулгуурлан тухайн жилийн төсвийн хязгаар, түүний дотор урсгал болон хөрөнгийн зардлын хэмжээг тогтоох хэрэгтэй болдог. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний үндэс болох ёстой⁴ бөгөөд “орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, хотын

³ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.3 дахь заалтад “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж тусгасан.

⁴ “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг

хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна” гэж Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан. Эндээс сум, дүүргийн төсөв нь сум, дүүргийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэхээр харагдаж байгаа ч уг хуульд сум, дүүргийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулах заалтыг огт тусгаагүй байна. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төсвийн бүх байгууллагын 60 орчим хувь нь сум, дүүргийн түвшинд ажиллаж, төрийн болон нийгмийн үйлчилгээг хүргэж буй тул Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн нийцлийг хангах шаардлага тулгарч байна. Иймээс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд “сум, дүүргийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө”-г боловсруулж хэрэгжүүлэх заалт нэмж тусгах хэрэгтэй.

9. Төлөвлөгөөний төслийн үр дүнгийн суурь болон зорилтот түвшнийг хэт ерөнхий тусгасан байгааг илүү нарийвчлах, хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудыг илүү тодорхой болгох, уялдаа холбоог хангахад анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

10. Төлөвлөгөөний төслийн 1 дүгээр тэргүүлэх чиглэлийн хүрээнд авах арга хэмжээний 1.1.1.1-т Бүгд Найрамдах Солонгос Улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг шинээр байгуулах, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр шинээр байгуулах, Тайландын Хаант Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсуудтай хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулах гэж заажээ. Харин олон улсын худалдааны онол, практикт түгээмэл хэрэглэгддэг худалдааны таталцлын загварыг ашиглан, Ази-Номхон далайн бүс нутгийн 31 орон болон Монгол Улсын эдийн засгийн харилцаанд тулгуурлан бидний хийсэн дүн шинжилгээгээр дээр нэр дурдсан 5 улсаас эхний дөрөвтэй нь Монгол Улсын хийх гадаад худалдааны потенциал хэмжээндээ хүрсэн гэж гарсан бол худалдааны потенциал хамгийн өндөр улсууд нь Төв болон Баруун Азийн Тажикстан (84%-аар нэмэгдүүлэх боломжтой), Армений (42%), Хятадын Макао (38%), Иран (20%) улс байна. Иймд цаашид төрөөс эдийн засгийн түншлэлийн талаар баримтлах бодлогын арга хэмжээг энэ чиглэлд хандуулах, илүү нарийвчилсан судалгаа, шинжилгээнд тулгуурлан шийдвэр гаргадаг байх шаардлагатай.

11. Төлөвлөгөөний төслийн 8 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлэх талаар 11 арга хэмжээ тусгасан атал шалгуур үзүүлэлтээр нь үүнтэй хамааралгүй “Дэлхийн энх тайвны үзүүлэлт”-ийг Хавсралт 2-т тусгажээ. Харин үүний оронд НҮБ-ийн Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комисс (UNESCAP)-аас гаргадаг INFORM зэрэг сөрөн тэсвэрлэх чадавхыг хэмждэг үзүүлэлтийг сонгох нь зүйтэй.

12. Хөгжлийн төлөвлөгөөний төслийн хүрээнд төсвийн санхүүжилт, зээл, тусламж нэмэгдэх нь төсвийн тэлэлт, өрийн дарамтыг нэмэгдүүлэх тул хуулийн “тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх” шалгуурыг хангасан төслийг хэрэгжүүлж, хөгжлийн төсөл, арга хэмжээний үр ашгийг сайжруулах шаардлагатай.

13. Төлөвлөгөөний төслийн 5 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 12 арга хэмжээнээс 10-ыг нь улсын төсвөөс санхүүжүүлэхээр төслийн Хавсралт 3-т заажээ. Гэтэл дэлхий нийтээр, тэр дундаа донор орнууд болон Азийн Хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагууд ногоон шилжилтийг дэмжихээ тодорхой зарласан энэ цаг үед тус төслүүдийг өөр эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг эрэлхийлэх хэрэгтэй байна.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

----- о О о -----

тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг хэлнэ (ХБТТУТХ-ийн 4.1.14 дахь заалт).

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр ба нэг жилийн хөгжлийн төлөвлөгөөний харьцуулалт

Алсын хараа 2050-ын зорилтуудаас:	2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан зорилтууд:	2022 оны хөгжлийн зорилтоос:	2023 оны хөгжлийн зорилтоос:	2024 оны хөгжлийн зорилтоос:	2025 оны хөгжлийн зорилтоос:
Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон дараах чиглэлийн төмөр замуудыг барих: “Таван толгой”-“Зүүн баян”; “Зүүнбаян”-“Ханги мандал”; “Нарийн сухайт”-“Шивээ хүрэн”; “Таван толгой”-“Гашуун сухайт”; “Сайншанд”-“Баруун-Урт”-“Хөөт”.	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын төсөл; Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн 267 км төмөр замын төсөл; Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай автозам;	Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барих; Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто замыг барих ажлыг эхлүүлэх;	Хөөт-Бичигт чиглэлийн 234.1 км төмөр замын төслийн ББ хангах; Хөөт -Чойбалсан чиглэлийн 192 км төмөр замын төсөл; Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах;	Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1,255 км төмөр зам, хилийн боомтын холболт; Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр зам;	Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн-Нарийн сухайт-Шинэжинст чиглэлийн 300 км төмөр зам барих; Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын 18.9 км төмөр зам барих;
4.2.34. Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангах дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөж, шинэ цахилгаан станц барьж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно. 4.2.36. Эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын эх үүсвэрийг барьж байгуулан импортын эрчим хүчний хараат байдлыг бууруулна.	Шинээр барих ДЦС: Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл, 90МВт; Багануурын дулааны цахилгаан станц төсөл; Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц; Өргөтгөл, шинэчлэл: ДЦС-4-ийн 1-4 турбо-генераторын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчлэх; Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-аар өргөтгөх;	Шинээр барих ДЦС: Эрдэнэбүрэнгийн УЦС барих төсөл, 90МВт; Багануурын ДЦС төсөл; Тавантолгойн 450 МВт-ын ДЦС; Багануурын ДЦС-ын төслийг эхлүүлэх, Өргөтгөл, шинэчлэлийн төсөл: ДЦС-2-ыг түшиглэн хийн ЦС байгуулах суурь судалгааг хийх;	Шинээр барих ДЦС: Эрдэнэбүрэнгийн УЦС барих төсөл, 90МВт; Багануурын ДЦС төсөл; Тавантолгойн 450 МВт-ын ДЦС; Чойбалсан ДЦС-ын хүчин чадлыг өргөтгөх, Өргөтгөл, шинэчлэл: ДЦС-2-ыг түшиглэн хийн ЦС байгуулах суурь судалгааг хийх Амгалангийн ДЦС-ыг өргөтгөх;	Шинээр барих ДЦС: Эрдэнэбүрэнгийн УЦС барих төсөл; Багануурын дулааны цахилгаан станцыг барих ажлыг үргэлжлүүлэх; Чойбалсан ДЦС-ын хүчин чадлыг өргөтгөх, 10 аймгийн төвд барих ДЦС, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв шинээр барих ажлыг үргэлжлүүлэх;	Шинээр барих ДЦС: Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барих; Тавантолгойн 300+150 МВт-ын цахилгаан станцын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийх; Багануурын цахилгаан станц барих; Багахангай /Бөөрөлжүүт/-н 300 МВт-ын дулааны цахилгаан станц барих Налайх дүүрэг 216 МВт-ын дулааны шинэ станц барих;

Тайлбар:

1. Хүснэгтийн нэгдүгээр мөрөнд “Алсын хараа-2050-, 2021-2025 оны Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төмөр замын бүтээн байгуулалт, шинэчлэлтийн төслүүдийг үзүүлсэн.
2. Хүснэгтийн хоёрдугаар мөрөнд “Алсын хараа-2050”, 2021-2025 оны Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан дулааны болон усан цахилгаан станцыг шинээр барьж байгуулах, хүчин чадлыг өргөтгөн шинэчлэх бүтээн байгуулалтын төслүүдийг үзүүлсэн.
3. Хүснэгтийн 3-6-р багануудад тодруулж бичсэн үсгээр “Алсын хараа-2050” болон 2021-2025 оны Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй боловч тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд шинээр нэмж тусгагдсан төмөр зам, эрчим хүчний салбарын томоохон төслүүдийн жишээг дурдсан.
4. Энэ хүснэгтэд жишээ болгон зөвхөн дэд бүтэц, эрчим хүчний салбарын томоохон хөрөнгө оруулалт шаардагдах зарим цөөн төслүүдийн жишээг үзүүлсэн бөгөөд бусад салбаруудын хөгжлийн төлөвлөгөө, зорилтуудад ийм жишээ маш олон байгаа болно.

Хавсралт 2

Монгол Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын зорилго, зорилт, төсөл, арга хэмжээ ба үр дүнгийн харьцуулалт

Тэргүүлэх чиглэл	Бодлогын зорилго	Зорилтууд	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөр-ийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үр дүнгийн үзүүлэлт	
							Суурь түвшин	Зорилтот түвшин
1. Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого	1.1	2	1.1	1	3	5	-	5
	1.2	20	1.2	3	7	10	8	10
			1.3	1	4	4	2	4
	1.3	8	1.4	3	15	19	17	19
	1.4	10	1.5	2	19	19	19	19
			1.6	1	7	7	7	7
	1.5	7	1.7	3	13	15	13	15
	1.6	11	1.8	3	26	26	26	26
2. Эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх хүний хөгжлийн бодлого	1.7	2	1.9	1	3	3	2	3
	Нийт	60	9	18	97	108	94	108
	2.1	3	0	0	0	0	0	0
	2.2	11	2.1	3	8	14	10	14
	2.3	8	2.2	3	9	21	21	21
	2.4	8	2.3	3	4	4	2	4
	2.5	12	2.4	1	4	4	0	4
	2.6	5	2.5	3	11	11	11	11
3. Шинжлэх ухаан, дэвшилтэт технологид тулгуурласан засаглалын бодлого	Нийт	47	5	13	36	54	44	54
	3.1	6	3.1	2	3	3	3	3
	3.2	7	3.2	1	7	7	7	7
	3.3	8	3.3	1	1	1	1	1
	3.4	12	3.4	2	9	9	8	9
			3.5	2	2	2	0	2
	3.5	3	3.6	1	1	1	0	1
	Нийт	36	6	9	23	23	19	23
4. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлого	4.1	4	4.1	0	0	0	0	0
	4.2	4		2	2	2	1	2
	4.3	4	4.2	1	5	5	4	5
	Нийт	12	2	3	7	7	5	7
5. Ногоон хөгжлийн бодлого	5.1	6	5.1	2	2	3	1	3
	5.2	11	5.2	4	10	15	14	15
	Нийт	17	2	6	12	18	15	18
6. Бүсчилсэн хөгжлийн бодлого	6.1	8	6.1	1	5	5	5	5
	6.2	6 бүс						
	Нийт	8	1	1	5	5	5	5
7. УБ хотын бүсчлэл-20 минутын хотын бодлого	7.1	8	7.1	2	8	8	4	8
	7.2	6						
	7.3	7	7.2	3	13	14	13	14
	Нийт	21	2	3	13	14	13	14
8. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар	8.1	3	8.2	1	5	5	5	5
	8.2	7	8.1	1	2	2	2	2
	8.3	12	8.3	3	16	17	14	17
	Нийт	22	3	5	23	24	23	25
НИЙТ	31	224	30	58	216	253	216	253

Монгол Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ ба санхүүжилтийн эх үүсвэртэй эсэхийн харьцуулалт

Тэргүүлэх чиглэл	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хөрөнгийн хэмжээ тодорхойгүй	Хөрөнгийн хэмжээ тодорхойгүй төсөл, арга хэмжээг хариуцах субъект
1. Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого	1.1	1	3	5	4	ЭЗХЯ
	1.2	3	7	10	2	ХХААХҮЯ
	1.3	1	4	4	1	ХХААХҮЯ
	1.4	3	15	19	4	УУХҮЯ
	1.5	2	19	19	1	ЗТХЯ
	1.6	1	7	7	0	
	1.7	3	13	15	3	ЭХЯ
	1.8	3	26	26	0	
	1.9	1	3	3	0	
	9	18	97	108	15	
2. Эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх хүний хөгжлийн бодлого	2.1	3	8	14	0	
	2.2	3	9	21	3	БШҮЯ
	2.3	3	4	4	3	ХНХЯ
	2.4	1	4	4	4	ХНХЯ
	2.5	3	11	11	0	
	5	13	36	54	10	
3. Шинжлэх ухаан, дэвшилтэт технологид тулгуурласан засаглалын бодлого	3.1	2	3	3	0	
	3.2	1	7	7	0	
	3.3	1	1	1	0	
	3.4	2	9	9	0	
	3.5	2	2	2	2	АТГ
	3.6	1	1	1	1	ТАЗ
	6	9	23	23	3	
4. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлого	4.1	2	2	2	1	ЭЗХЯ
	4.2	1	5	5	5	СЗХ, МБ
	2	3	7	7	6	
5. Ногоон хөгжлийн бодлого	5.1	2	2	3	2	БОАЖЯ, СЗХ
	5.2	4	10	15	0	
	2	6	12	18	2	
6. Бүсчилсэн хөгжлийн бодлого	6.1	1	5	5	2	ЭМЯ, ЭЗХЯ
	1	1	5	5	2	
7. УБ хотын бүсчлэл-20 минутын хотын бодлого	7.1	2	8	8	4	
	7.2	3	13	14	0	
	2	3	13	14	4	
8. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар	8.2	1	5	5	0	
	8.1	1	2	2	0	
	8.3	3	16	17	1	ОБЕГ
	3	5	23	24	0	
НИЙТ	30	58	216	253	44	17.4